



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 1/64

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид эрүүл мэндийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх журам"-ыг нэгдүгээр, "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (Г.Ууганцэцэг), Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжлийн салбар зөвлөл (З.Хишигсүрэн), Сэргээн засах судлалын мэргэжлийн салбар зөвлөл (А.Балжинням)-д, хариуцсан чиг үүргийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв)-т үүрэг болгосугай.

5. Энэ журам гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 462 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН

141260335

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 02
дугаар сарын 26-ны өдрийн 1/64 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИД ЭРҮҮЛ МЭНДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журам нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид (цаашид “хохирогч” гэх) сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулж, хохирогчийг нийгмийн идэвхтэй гишүүн болж нийгэмших, амьдралын чанарыг нь нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

1.2.Хохирогчид Хүн худалдаалахтай тэмцэх тухай, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Хувийн мэдээлэл хамгаалах тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг мөрдлөг болгож сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

1.3.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн үйл ажиллагаа, чадвар алдагдсан тохиолдолд Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан “Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх журам” болон оношилгоо, эмчилгээ, үйлчилгээ үзүүлэхэд баримтлах стандарт, заавар, зөвлөмжийг баримтална.

1.4.Хохирогчид сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хуульд зааснаас бусад тохиолдолд түүний зөвшөөрлийг, насанд хүрээгүй, хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, сэтгэцийн эмгэгтэй, хэлний бэрхшээлтэй, эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэрч, хохирогчийг хамгаалах байгууллагын албан ёсны төлөөлөгчийн оролцоотой зөвшөөрлийг бичгээр авна.

Хоёр.Хохирогчид сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим

2.1.Хохирогчид сэргээх засах тусламж, үйлчилгээ үзүүлэхэд дараах зарчмыг баримтална:

- 2.1.1. хүний эрх болон нэр төрийг хүндэтгэх;
- 2.1.2. ялгаварлан гадуурхахгүй байх;
- 2.1.3. аюулгүй байдлыг хангах;
- 2.1.4. хор хохирол учруулахгүй байх;
- 2.1.5. гэмтлийн талаарх мэдээлэлд суурилсан, хохирогчид чиглэсэн, жендэрийн мэдрэмжтэй үйлчилгээ үзүүлэх;
- 2.1.6. хохирогчийг буруутгахгүй байх;
- 2.1.7. хохирогчийн хувийн болон эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах;
- 2.1.8. хохирогчийн онцлог хэрэгцээг тогтоож, тохирсон тусламж, үйлчилгээг үзүүлэх;
- 2.1.9. хүнлэг, энэрэнгүй, ёс зүйтэй байх.

2.2.Хохирогчид сэргээх засах тусламж, үйлчилгээг нийгэм, хамт олонд түшиглэж явуулна.

Гурав. Хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

3.1.Хохирогчид сэргээн засах тусламж, үйлчилгээг тусгай зөвшөөрөл бүхий төрийн өмчийн сэргээн засах эрүүл мэндийн байгууллага цогц, эсхүл дагнасан байдлаар үзүүлнэ.

3.2.Сэргээн засах тусламж, үйлчилгээ нь чанартай, хүнд сурталгүй, үнэ төлбөргүй, хохирогчийн нас, хүйс, хэл, соёлын болон шашны онцлог зэрэг нөхцөл байдал, онцгой хэрэгцээ, ашиг сонирхолд нийцсэн байна.

3.3.Хохирогчид үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээ нь биеийн сэргээн засал, хэл заслын, хөдөлмөр хөдөлгөөн заслын үйлчилгээ, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзлэг, эмчилгээ, хоол тэжээлийн дэмжлэг, эмийн эмчилгээ, тусламж, үйлчилгээний дараах хяналтын үйл ажиллагааг хамарна.

3.4.Хохирогчид сэргээн засах тусламж, үйлчилгээг зөвхөн сэргээн засахын эмч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч, сэтгэл засалч болон сэргээн засахын бусад мэргэжлээр мэргэшсэн, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтэн үзүүлнэ.

3.5.Сэргээн засах эмчилгээ, үйлчилгээ үзүүлэхийн өмнө сэргээн засал судлалын эмч, мэргэжилтэн нь хохирогчид өвчний мэдээлэл, явцын талаар тайлбарлаж, сэргээн засах эмчилгээний агуулга, ач холбогдлын талаар танилцуулж үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авна.

3.6.Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэхийн өмнө эмч, мэргэжилтэн нь тухайн хохирогчийн хувийн онцлогт тохирсон сэргээн засах эмчилгээний төлөвлөгөө боловсруулна.

3.7.Сэргээн засах эмчилгээ, үйлчилгээг дараах дарааллын дагуу тасралтгүй үргэлжлүүлэн явуулна:

- 3.7.1. сэргээн засахын эмч, хөдөлгөөн, хөдөлмөр, хэл засалчийн үзлэг, оношилгоо, үнэлгээ, зөвлөгөө;
- 3.7.2. сэргээн засах багийн зөвлөгөө, сэргээн засах тусламж, үйлчилгээний төлөвлөгөө;
- 3.7.3. хувь хүнд тохирсон төлөвлөгөөний дагуу үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээ;
- 3.7.4. тусламж, үйлчилгээний үр дүн, хяналт;
- 3.7.5. сэргээн засах багийн давтан үзлэг, үнэлгээ.

3.8.Сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ сэргээн засахын үйлчилгээний стандарт, эмнэл зүйн зааврын дагуу хийнэ.

3.9.Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад эмчилгээний хяналтын хуудас болон холбогдох бусад хуудсуудыг ашиглана.

3.10.Хөдөлгөөн, хөдөлмөр, хэл засалч нь мэргэжлийн үнэлгээ, тусламж, үйлчилгээг гардан гүйцэтгэнэ.

3.11.Хэвтүүлэн эмчлэх, өдрөөр, гэрээр үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээг хохирогчийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан холбогдох журамд заасан хугацаагаар үзүүлнэ.

3.12.Хохирогч бэлгийн хүчирхийллийн эрсдэл, шалтгаантай тохиолдолд 72 цагийн дотор жирэмслэлтээс хамгаалах хэрэгслээр хангах, өртөлтийн дараах халдвараас сэргийлэх арга хэмжээ авах, БЗДХ, ДОХИДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ, сэтгэлзүйн анхны тусламж, нотлох баримтыг бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд аюулгүй байдлыг ханган хамгаалах байранд нэн даруй холбож өгнө.

Дөрөв. Хохирогчид сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэхэд баримтлах нийтлэг хэм хэмжээ

4.1.Хохирогчид сэргээн засах эмчилгээ, үйлчилгээ үзүүлэхэд дараах нийтлэг хэм хэмжээг мөрдөнө:

- 4.1.1. хохирогчийн эрүүл мэндийг тодорхойлох, оношлох, сэргээн засах, эмчлэхэд шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх;
- 4.1.2. шаардлагатай тохиолдолд хохирогчтой хийх уулзалт, ярилцлага, эмчилгээг хаалттай буюу бусад хүнд сонсогдохооргүй орчин нөхцөлд ганцаарчлан явуулах бөгөөд хохирогчтой ижил хүйсийн эмч, сэтгэл зүйч, эрүүл мэндийн нийгмийн ажилтныг ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 4.1.3. сэргээн засах эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх үеийн бүхий л мэдээллийн нууцыг хадгалах бөгөөд зөвхөн түүний зөвшөөрлийн үндсэн дээр аюулгүй байдлыг хангах, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- 4.1.4. холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд хохирогчийн мэдээллийн нууцлалыг хадгалах нөхцөлтэйгөөр танилцуулж, ярилцлагын тэмдэглэлд энэ тухай тусгаж, гарын үсэг зуруулна.

Тав.Холбогдох үүрэг бүхий талуудтай хамтран ажиллах

5.1.Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага, эмч, мэргэжилтнүүд нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, албан тушаалтан болон иргэний нийгмийн байгууллага, хохирогчийн гэр бүл, бусад этгээдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх зэргээр идэвхтэй хамтран ажиллана.

5.2.Бусад төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд хохирогчийг дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагад яаралтай шилжүүлэх арга хэмжээг авна.

5.3.Энэхүү журмын 5.2-т заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд гэр бүлийн гишүүд эсхүл холбогдох байгууллагад яаралтай мэдэгдэнэ.

5.4.Сэргээн засах эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх явцад хохирогч хүн худалдаалах болон бусад эрүүгийн хэргийн хохирогч болох эрсдэлтэй байх нөхцөл байдал илэрсэн тохиолдолд энэ тухай цагдаагийн байгууллагад шуурхай мэдээлнэ.

Зургаа. Санхүүжилт

6.1.Хохирогчид үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 18.1.10-д заасны дагуу тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлнэ.

Долоо. Бусад зүйл

7.1.Энэ журмыг зөрчсөн бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.